

БАТЛАВ:
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

**БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу энэхүү үзэл баримтлалыг боловсруулав.

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогын үргэлжлэл болох Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршийн суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” зорилтыг тус тус дэвшүүлсэн. Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангахад тулгуур болох боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлж буй хууль тогтоомж хангалтгүй байгаагаас үүдэлтэй Монгол Улсын Их Хурлаас Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлан гаргажээ.

Хэдийгээр Боловсролын багц хуулиуд анх удаа цогцоороо шинэчилсэн найруулга хэлбэрээр батлагдсан нь салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боловсролд шинэ хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, боловсролын санхүүжилтийг сайжруулах, боловсролын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох сайн талтай ч хууль хэрэглээний явцад зарим нэг дутагдалтай зүйлийг засах, илүү боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор урган гарч байгаа нь энэхүү төслийг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Тухайлбал, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т “сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох,” гэж хуульчилсан хэдий ч Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлан гаргасан “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай

хууль” 2025 оны 6 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээр аймгийн төвийн сумдууд, томоохон суурин газрууд улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот болж өөрчлөгдсөнөөр тэнд ажиллаж, амьдарч буй боловсролын салбарын багш, ажилтнууд дээрх тэтгэмжид хамрагдахгүй, хохирох эрсдэл үүсээд байна. Мөн Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6-д шинээр тусгаж өгсөн “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах.”гэсэн заалтын зарим хэт хатуу шаардлагыг хасахгүй бол энэ заалтын дагуу хүсэлт өгсөн нийт багш, ажилтны 60 гаруй хувь нь хамрагдаж чадахгүй байна гэсэн харамсалтай тоог Боловсролын яамнаас ирүүлж байна.

2023 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд сонгуулийн холимог тогтолцоогоор байгуулагдсан, 126 гишүүн бүхий шинэ парламент нь хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатанд хүн төвт үзэл санаанд суурилсан, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан байх зарчим, шаардлагыг тэргүүн эрэмбэд тавина гэсэн нь энэхүү хуулийн төслөөр дамжуулан боловсролын харилцаанд оролцогч багш, ажилтны хөдөлмөрлөх болон бусад эрх, эрх чөлөөг хангах, суралцагсдын сурч, боловсрох эрх чөлөөг хамгаалах, тэдний амьдралаас урган гарсан зүй ёсны шаардлагыг гаргаж ирснээрээ онцлогтой.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /ЮНЕСКО/-ын Ерөнхий захирлын урилгаар 2015 оны 5 дугаар сард БНСУ-ын Инчон хотноо зохион байгуулсан Боловсролын дэлхийн чуулга уулзалтаар батлан гаргасан Боловсрол 2030: Инчоны тунхаглалаар заасан заалтуудын хэрэгжилтийг дүгнэхэд 5 жилийн хугацаа үлдээд байна. Гэсэн хэдий ч “Боловсрол 2030 хөтөлбөрийн амжилт нь зөв бодлого, төлөвлөлт, үр дүнтэй хэрэгжилтэд оршино. Мөн улс орнуудын, тэр дотроо боловсролын бүх түвшинд чанартай боловсрол эзэмшүүлэхэд хүндрэлтэй улс орнуудын санхүүжилтыг сайтар төлөвлөж, зардлыг нэмэгдүүлэх замаар Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилгын бодлогыг бодит ажил болгон хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна. Иймээс тухайн орны нөхцөл байдалд нийцүүлэн төрөөс боловсролын салбарт зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх хэрэгцээг тодорхойлж, олон улс, бүс нутгийн жишгийг баримтлан дотоодын нийт бүтээгдэхүүний 4-6 хувийг эсхүл улсын төсвийн 15-20 хувийг боловсролын салбарт зарцуулахыг уриалж байна.” гэсэн уриалгыг Монгол улс хэрэгжүүлэхгүй байгаа нь туйлын харамсалтай. Ганцхан жишээ хэлэхэд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар боловсролын салбарт Дотоодын нийт бүтээгдэхүүний 4,7 хувийг, төсвийн нийт зарлагын 13,3 хувийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Иймээс боловсролын салбарын төсвийн санхүүжилтийг Боловсрол 2030 Инчоны тунхаглалд зааснаар хуульчилж өгснөөр улс эх орны хөгжил дэвшлийн амин судас болсон боловсролын салбарын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, суралцагсдын сурах орчин сайжирч, салбарын

багш, ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааг дээшлүүлэх үндсэн хүчин зүйл болох юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгох” болон “Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана.” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнд хийсэн шинжилгээ судалгаа нь энэ хуулийн төслийг боловсруулах судалгаа, шинжилгээний үндэслэл болсон юм. Судалгааны дүгнэлтээс үзэхэд бүх шатны боловсролын зорилгыг дэлхийн болон улс, орны хөгжлийн шинэ хэрэгцээ шаардлага, чиг хандлагад нийцүүлэх, албан, албан бус боловсролын тогтолцоонд шинэчлэл хийх, боловсролын байгууллагын бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой болгох, үр ашгийг сайжруулах, боловсролын салбар дахь хүний нөөцийн (багшийн) хомсдлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах, сургалтын чанар, үр ашгийг сайжруулах бодит хэрэгцээ шаардлага үүсээд байна.

2022 онд Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага /OECD/-аас авч хэрэгжүүлдэг Programme for International Student assessment /PISA/ буюу сурлагын амжилтын олон улсын үнэлгээнд Монгол улс анх удаа хамрагдлаа. PISA нь суурь боловсрол эзэмшсэн 15 настай суралцагчид танхимаар олж авсан мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямра хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын олон улсын үнэлгээ юм. Энэ үнэлгээний үр дүнгээр Монгол улсын 15 настай суралцагчид 81 орноос **математикийн ур чадвараар 47 дугаар байр, унших чадвараар 65 дугаар байр, байгалийн ухааны ур чадвараар 53 дугаар байрт** эрэмбэлэгджээ. Мөн Монголын 15 настай сурагчдын үндсэн 3 чиглэлийн сорилын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтийг бусад улс оронтой харьцуулан үзэхэд ЭЗХАХБ болон Азийн уднджаас статистикийн хувьд доогуур оноо авсан, ЭЗХАХБ-ын бусад орны үе тэнгийнхнээсээ математикийн чиглэлээр 2 жил, байгалийн ухаан болон унших чадварын чиглэлээр тус тус 5 жилээр хоцорчээ гэж ойлгогдохоор байна. Энэ нь боловсролын салбарын санхүүжилт, багшлах боловсон хүчний хомсдол, ур чадвараас шууд болон шууд бусаар шалтгаалах нь тодорхой юм.

2024-2025 оны хичээлийн жилийн эхэнд сургуулийн өмнөх боловсролын түвшинд 508, ерөнхий боловсролын түвшинд 4292, мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд 82 багшийн дутагдалтай байгаа, 2030 он гэхэд 23 мянга гаруй багшийн хомсдолд орно гэсэн тооцоо судалгааг Боловсролын яамнаас ирүүлсэн. Эндээс багш бэлтгэх тогтолцоонд эрчимтэй шинэтгэл хийх, багшийн

цалин хөлс, нийгмийн баталгааг онцгойлон анхаарч, цогц байдлаар шийдэхгүй бол багшийн хомсдол, боловсон хүчний нөөц улам ихсэх бодит нөхцөл тулгарсныг илтгэнэ.

Иймд Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилтыг биелүүлэх, боловсролын салбарыг орчин үеийн чиг хандлагад тулгуурлан хөгжүүлэх, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг шинээр тодорхойлох, сургалтын чанар, агуулгыг хүний хөгжил, улс орны хөгжлийн ирээдүй, өрсөлдөх чадвар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, цаашдын төлөв байдалд нийцүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн төслийг боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, хөгжлийн зорилт, зарчим, удирдлага, зохион байгуулалт, иргэн насан туршдаа тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшихтэй холбоотой харилцааг болон боловсролын санхүүжилтийг өөрийн орны болон дэлхий нийтийн хөгжлийн шаардлагад нийцүүлэх зорилгыг удирдлага болгон боловсруулна.

Хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлбэр төрлөөр боловсруулагдах ба нийт 5 зүйлтэй бөгөөд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлон тусгана.

Төслийн 1 дүгээр зүйлд багш, багшийн туслах, боловсролын удирдах болон мэргэжлийн ажилтан, боловсролын нийтлэг үйлчилгээний ажилтан гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг бий болгон хуульчилахаар тусгах;

Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах болон мэргэжлийн ажилтны үндсэн цалинг улсын дундаж цалингаас багагүй байхаар тооцож, инфляцийн түвшинтэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоох;

Хувийн хэвшлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь багш, удирдах болон мэргэжлийн ажилтны үндсэн цалинг харгалзах түвшний төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах болон мэргэжлийн ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлстэй тэнцүү байхаар тогтоох;

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн боловсролын нийтлэг үйлчилгээний ажилтны үндсэн цалин болон багшийн үндсэн цалингийн зөрүү хорин хувиас илүүгүй байх;

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт хичээллэх суралцагчийн тоо боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс

тогтоосон нормативаас хэтэрсэн тохиолдолд хүүхдийн тоотой уялдуулсан цалингийн нэмэгдэл олгох;

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн анги, бүлэг удирдсан багшийн нэмэгдлийг тухайн анги, бүлгийн суралцагчийн тоотой уялдуулан олгох;

Аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтсийн даргыг болон төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль болон насан туршийн суралцахуйн төвийн захирлыг таван жилийн хугацаатай томилох бөгөөд ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн, удирдах ажилтны манлайлал, хариуцлага, ёс зүйтэй байдлыг харгалзан дахин нэг удаа гурван жилийн хугацаагаар улируулан томилох;

Төрөөс боловсролын салбарт дотоодын нийт бүтээгдэхүүний 7-гоос доошгүй хувийг, эсвэл улсын төсвийн нийт зардлын 20-оос доошгүй хувийг зарцуулдаг болох.

Төслийн 2 дугаар зүйлд Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, мэдлэг чадвартай, ёс суртахуунтай, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэхэд оршиж байхаар тодорхойлон хуульчлах;

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид төрөөс сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний амжиргааны тэтгэлэг хэлбэрээр үзүүлэх, багш мэргэжлээр амжилттай суралцан амжиргааны тэтгэлэг авсан хугацааг багшаар ажилласанд тооцох;

Хөдөлмөрийн онцлогийг харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарт ажлын 21 өдөр, бусад ажилтанд ажлын 27 өдөр, багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох;

Тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багш, ажилтан нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах;

Сум, баг, Нийслэл Улаанбаатар хотод харьяалагдах улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотоос бусад хот, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн багш, ажилтанд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд 25-аас дээш жил ажиллаж, тэтгэврийн

даатгалын шимтгэл төлсөн багш, боловсролын мэргэжлийн болон удирдах ажилтан өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 настай тэтгэвэрт гарч болох бөгөөд тэдгээрт ажилласан нэг жилийг нь нэг аравны таван /1,5/ жилээр тооцон Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах;

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, буцалтгүй тусламж авсан багш, ажилтныг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд үргэлжлүүлэн ажиллуулсан бол түүний ажлын нормыг тохируулах, цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал, тэтгэмжийг хэрхэн олгох журмыг Засгийн газар батлах;

Төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын хувьсах зардлын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин үржүүлсэнтэй тэнцүү байхаар тооцон инфляцийн түвшинтэй тэнцүү хувиар жил тутам шинэчлэн тогтоох;

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хувь, хэмжээг инфляцийн түвшинтэй тэнцүү хувиар жил бүр шинэчлэн тогтоох зэрэг зохицуулалтыг хуульчлан тусгах;

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль болон насан туршийн суралцахуйн төвийн захирлын албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг илүү нарийвчлан тусгахаар хуулийн төслийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна:

Боловсролын зорилго, зорилт, зарчим, иргэн боловсрол эзэмших арга хэлбэр, эрх, үүрэг тодорхой болж, дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлагад нийцсэн байна.

Боловсролын санхүүжилт нь боловсролын зорилго, стандартын хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж, боловсролын үйлчилгээний гүйцэтгэл, чанар, үр дүнд чиглэсэн байх бөгөөд нэгж суралцагчийн хувьсах зардлын хэмжээ нэмэгдэж, сурч боловсрох орчин нөхцөл сайжирна. Мөн багш бэлтгэх тогтолцоонд дэвшил гарч, багш мэргэжил эзэмшихэд өрсөлдөөн нэмэгдэхийн хамт Боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгаа бодитой дээшилж, ирээдүйд учрах хүний нөөцийн хомсдлоос хамгаалж, багш мэргэжилтний үнэлэмж, нэр хүнд дээшлэн, мэргэжлийн ур

чадвар сайжирч, тэр хэрээр боловсролын чанарт ахиц гарна.

Боловсролын ерөнхий хууль нь Монгол Улсын Их Хурлаас дэвшүүлж буй хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатанд хүн төвт үзэл санаанд суурилсан, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан байх зарчим, шаардлагад нийцнэ.

Улс эх орны хөгжлийн үндсэн хэмжүүр нь хүний хөгжил байх гол зарчмыг үндэс болгон хуулийн төслийг боловсруулах ба иргэн бүр эрүүл байж, боловсрол эзэмшиж, амжиргаандаа хүрэлцэхүйц орлоготой болох боломжийг бүрдүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулж, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, хүн амын амжиргааны түвшнийг дээшлүүлэх, мэдлэгт суурилсан нийгэм, ур чадвартай, зөв хандлагатай Монгол хүнийг төлөвшүүлэх зорилгод нийцнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд тухайн хуулийг дагалдан боловсруулах хуулийн төсөлгүй болно.